

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит тавдугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хуралдав.

#### **Хуралдаанаар:**

- Боловсрол, эрүүл мэнд, спортын салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гарган аймаг орон нутгийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан дараах хүмүүсийг хамт олон, нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг тус тус дэмжиж төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар,
- Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт 60 гаруй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэн, зүүн бүсийн аймгуудыг эх орны үржил шимт хөрсөнд ургасан чанар сайтай улаан буудайн гурил, хүнсний ногоо, малын тэжээлээр хангаж, тогтмол 100 гаруй ажлын байрыг бий болгон улс орны эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулж байгаа гурил, тэжээлийн ууган үйлдвэрүүдийн нэг “Дорнод гурил” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг “Алтан гадас одон”-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр шийдвэрлэв.
- Чойбалсан хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, харьяа төрийн байгууллагуудыг нэгдсэн нэг ойлголттой болгож, цаашид хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлох ажлын хэсгийг байгуулав.
- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг баталж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 81 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүн Батжаргалын Энхтуяагийн ажиллах хугацаа дууссан тул Иргэний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөв.
- Төр, хувийн хэвшлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг дэмжиж батлав.
- Дорнод аймгийн нутаг дэвсгэрт отроор нүүдлэн ирж буй болон малчид, мал бүхий иргэд оршин суугаа газраасаа тус аймгийн нутаг дэвсгэрт малын шилжилт хөдөлгөөн хийхэд хяналт тавих, зохицуулах ажлын хэсгийг байгуулав.
- Дорнод аймгийн нутаг дэвсгэрт газрын тос, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаатай

танилцаж, хяналт шалгалт хийх, ажиллагсдын ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, цалин нийгмийн асуудлын талаарх мэдээллийг сонсох, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулав.

### **АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар 05-ны өдрийн хурлаар Дорнод аймгийн нутаг дэвсгэрт отроор нүүдлэн ирж буй болон малчид, мал бүхий иргэд оршин суугаа газраасаа тус аймгийн нутаг дэвсгэрт малын шилжилт хөдөлгөөн хийхэд хяналт тавих, зохицуулах ажлын хэсгийг байгуулсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын хорооны дарга Ж.Цогтбаатараар ахлуулсан Төлөөлөгч Ч.Эрдэнэбат, Ө.Амарсайхан, Д.Базаргүр, П.Эрхэмбаяр, Б.Оюунболд болон бусад албаны хүмүүс отор, нүүдэл болон малын шилжилт хөдөлгөөний улмаас сумдад үүсч буй хүндрэлтэй нөхцөл байдлыг газар дээр нь дүгнэх, сумын удирдлагууд, хариуцсан албан тушаалтантан, багийн Засаг дарга, иргэдийн нийтийн хурлын дарга, малчдын төлөөлөлтэй санал солилцох, оторлогч мал бүхий малчидтай уулзалт хийх замаар бодлогын асуудлыг аймгийн түвшинд тогтоох үндсэн зорилготой сумдад ажиллав.

### **Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2014 оны А/445 дугаар захирамжаар баталсан “Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тайлан боловсруулах, түүнийг үнэлж дүгнэх журам”, аймгийн Засаг даргын 2020 оны А/44 дүгээр “Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумдаас авах мэдээ, тайлангийн хуваарь батлах тухай” захирамжийн дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх 24 агентлаг, 14 сумдын жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд нийтлэг зөвлөмжийг 4/477, 4/478 албан тоотуудаар тус тус хүргүүлж ажиллав.

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтны шуурхай хуралдааны хэрэгжилтэд аймгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар хэрхэн хэрэгжиж байгаа болон бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2020 оны А/44 дүгээр “Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумдаас авах мэдээ, тайлангийн хуваарь батлах” тухай захирамжийг тус тус үндэслэн 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Коронавируст /Covid-19/ халдварт цар тахал гарсантай холбоотойгоор 2020 онд аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралдаан нийт 16 удаа хуралдаж, 82

заалт бүхий үүрэг даалгавар гарсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 86.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралдаан 03 дугаар сард нийт 4 удаа хуралдсан бөгөөд хурлын тэмдэглэлийг албажуулж газар, хэлтэс, албаны дарга нарт хүргүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Dornod gov.mn сайтад тухай бүр байршуулж ажиллалаа.

## ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР

Орон нутгийн нийт орлого 21947,5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 20303,7 сая төгрөг, үүнээс татварын орлого 5881,2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 5213,2 сая төгрөгт хүрч 668,0 сая төгрөгөөр тасарч, татварын бус 16066,3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 15090,5 сая төгрөгт хүрч 975,7 сая төгрөгөөр тасарлаа.

### Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	21,947,498,600.00	20,303,741,447.79	(1,643,757,152.21)	92.51
003 ТАТВАРЫН ОРЛОГО	5,881,205,600.00	5,213,165,164.58	(668,040,435.42)	88.64
004 Орлогын албан татвар	3,738,193,700.00	3,571,473,279.04	(166,720,420.96)	95.54
016 Хөрөнгийн албан татвар	276,165,900.00	418,787,373.62	142,621,473.62	151.64
021 Бусад татвар, төлбөр, хураамж	1,929,475,300.00	1,286,967,382.12	(642,507,917.88)	66.70
90041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,066,293,000.00	15,090,576,283.21	(975,716,716.79)	93.93
042 Нийтлэг татварын бус орлого	1,558,551,600.00	1,346,357,245.21	(212,194,354.79)	86.39
049 Хөрөнгийн орлого	0.00	18,355,000.00	18,355,000.00	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	11,696,636,800.00	11,519,643,900.00	(176,992,900.00)	98.5
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	10,974,461,600.00	11,102,030,500.00	127,568,900.00	101.2
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	722,175,200.00	417,613,400.00	(304,561,800.00)	57.8

## ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 15472.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 10084.4 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 1184.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 7163.0 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

## Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,405,830,300.00	16,587,995,864.11	(7,817,834,435.89)	68.0
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	10,966,001,900.00	9,217,583,596.47	(1,748,418,303.53)	84.1
Ажиллогччооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	1,475,067,200.00	1,247,603,757.83	(227,463,442.17)	84.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,038,755,800.00	1,147,683,614.00	(891,072,186.00)	56.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,101,873,900.00	752,238,534.13	(349,635,365.87)	68.3
Б. ХӨРСНГИЙН ЗАРДАЛ	3,488,043,400.00	821,307,942.00	(2,666,735,458.00)	23.5

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

## **Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж ажилласан.

Иргэн Б.Батчимэгийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг Дарга хариуцагчтай захиргааны хэргийн шүүх хуралд оролцсон.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг гаргаж Аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхдээ анхаарах зөвлөмжийг 2 удаа аймгийн 14 сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нарт хүргүүлсэн.

“Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт оролцсон.

“Нэг цонхны үйлчилгээний цэг”-т ажиллаж байгаа ажилтан нарт 3 сарын хугацаанд хэрэглэгдэх маск, санитол, нүүрний хаалтыг аймгийн Онцгой комисст хүсэлт гаргаж, шийдвэрлэж өгсөн.

Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 17 дугаар захирамжийг Жаст ойл ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эс зөвшөөрч, 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр давж заалдах журмаар гомдол гаргасан бөгөөд тус гомдлыг хариуцагчийн зүгээс эс зөвшөөрч хариу тайлбарыг гаргасан.

Ноосны үйлдвэр, намын байр, СМУ-ын 30 дугаар байруудтай холбоотой гурван иргэний хэрэгт танилцуулга болон холбогдох бусад материалуудыг бэлдэж, цэгцэлсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу жилийн хугацаанд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны талаар холбогдох саналыг хүргүүлсэн.

Аймгийн онцгой комиссоос гарч буй аливаа шийдвэрийг албажуулж тогтоолын төслийг бэлдсэн.

Эрх зүйн хөтөч сургалтанд хамрагдсан аймгийн 14 сумын 25 албан хаагчдад гэрчилгээ, гарын авлага 2 ширхэг гардуулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, зардлын тооцоог Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албад хүргүүлэв.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2021 оны төлөвлөгөөг боловсруулж, баталсан.

Аймгийн Эрүүл мэндийн газар луу Коронавирусын төлбөртэй шинжилгээ хийх журмыг төслийг хянан хүргүүлэв.

## **Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **Аймаг, орон нутагтаа зохион байгуулсан биеийн тамир, спортын арга хэмжээ:**

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос иргэдийг идэвхтэй хөдөлгөөнд уриалах, хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжих, өөрөө өөрийгөө ялан дийлэх, амьдралын зөв дадал хэвшүүлэх, иргэдийн гүйлтийн болон технологийн боловсролд зориулж “Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” биеийн тамирын арга хэмжээг 21 аймаг, 9 дүүргийн иргэдийн дунд 2021 оны 03 дугаар сарын 15-аас 28-ны өдрийн дуустал 14 хонгийн турш цахимаар зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Дорнод аймгийн 14 сум болон төрийн болон төрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд идэвхтэй оролцож, 1633 оролцогч нийт 14868 км зам туулж, дараахь амжилтуудыг үзүүллээ.

21 аймгаас нийт оролцогчдын тоогоор 3 дугаар байр,

21 аймгаас нийн туулсан километрээр 6 дугаар байр,

Зүүн бүсэд оролцогч, туулсан километрээр 1 дүгээр байр, хүн амын харьцуулсан тоогоор 2 дугаар байранд тус тус шалгарлаа.

Дорнод аймагт “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” арга хэмжээг амжилттай зохион байгуулж, шилдэгүүдийг шалгаруулж, “Батламж” гардуулсан.

#### ***Тамирчид ангилалд:***

##### ***Эрэгтэй:***

1. Баян-Уул сумын харъяат Т.Цолмон 866 км зам,
2. Зэвсэгт хүчний 085 дугаар ангийн Э.Эрэмгийбаатар 377,9 км зам,
3. Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн Д.Будбаатар,

##### ***Эмэгтэй:***

1. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн цахим гүйлтийн оролцогч Б.Сарангуа 510 км зам,
2. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн цахим гүйлтийн оролцогч Г.Уугантуяа 398,9 км зам
3. Аймгийн Прокурорын газрын цахим гүйлтийн оролцогч Г.Наранцацралт 176,7 км зам,

#### ***Иргэд ангилалд:***

##### ***Эрэгтэй:***

1. “Ольхон” ХХК-ийн цахим гүйлтийн оролцогч Ц.Цогтжаргал 231,3 км зам,
2. Аймгийн Скаутын Холбооны Тэргүүн Ж.Зоригтбаатар 222,9 км зам,
3. “ДБЭХС” ТӨХК-ийн цахим гүйлтийн оролцогч Б.Батзориг 114,5 км зам,
4. Хэрлэн сумын цахим гүйлтийн оролцогч Э.Эрдэнэсүх 121 км зам,

***Эмэгтэй:***

1. Улаанбаатар хотоос цахим гүйлтийн оролцогч Ю.Туяа 174,5 км зам,
2. Улаанбаатар хотоос цахим гүйлтийн оролцогч Д.Гантуяа 153,7 км зам,
3. Хэрлэн сумын цахим гүйлтийн оролцогч Г.Сарантуяа 108,1 км зам,
4. БОЭТ-ын хавдарын сувилагч Б.Алтантуяа 96,0 км зам,

***Байгууллагаас:***

1. Аймгийн Цагдаагийн газар 107 алба хаагчийг оролцуулж, нийт 321 км зам,

***Сумдаас:***

1. Халхгол сум

***Ерөнхий боловсролын сургуулиас:***

Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль хамгийн олон оролцогч, туулсан км-ээр нийт оролцсон байгууллагуудаас шалгарлаа.

**Зохион байгуулалтын арга хэмжээ:**

Засгийн газрын газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу “Урьдчилан сэргийлэх багц”-ын үзлэгт нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан.

Спортын 9 /бадминтон, сагсан бөмбөг, бокс, бөхийн төрөл, волейбол, хөл бөмбөг, хөнгөн атлетик, үндэсний сур, эрүүлжүүлэх бүжиг/ дугуйланд тамирчид болон насанд хүрэгчид /сонирхогч/ Даваа-Бямба гарагуудад 07:00-20:00 цаг хүртэл бэлтгэл сургуулилтыг цагийн хуваарийн дагуу хийхдээ Ковид-19 цар тахлын үед ажиллах халдвар хамгааллын зөвлөмжийг тогтмол мөрдөн ажилласан.

Спортын 7 дугуйланд нэг өдрийн бэлтгэл сургуулилтад /сагсан бөмбөг 31, бокс 40, бөхийн төрөл 47, волейбол охид 36, хөвгүүд 32, хөл бөмбөг 59, хөнгөн атлетик 24, үндэсний сур 38/ өглөө, үдээс хойшхи бэлтгэлд нийт 307 тамирчид,

Насанд хүрэгчдийн /сонирхогч/ эрүүлжих бүжиг 13, бадминтон 15, волейбол 18, бокс 10 нийт 56 хүн тус тус хамрагдсан.

Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх дадлага, сургуулилтыг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ажилчид болон бэлтгэл, сургуулилтад хамрагддаг тамирчдыг хамруулан зохион байгуулав.

### **Сургалт, семинар:**

Удирдлагын академи Мэргэшил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа 2050” сэдэвт богино хугацааны зайн 40 цагийн сургалтад 2 албан хаагч амжилттай хамрагдав.

Монголын Хөл бөмбөгийн Холбооноос зохион байгуулсан Эмэгтэй багийн дасгалжуулагчийн 2 өдрийн, Азийн Хөл бөмбөгийн Холбооны В ангилалын дасгалжуулагчийн мэдлэг сэргээх 3 өдрийн цахим сургалтад 1 албан хаагч

### ***Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг***

#### ***Боловсрол, соёл, урлагийн газар***

### **Танхимын сургалт:**

Ерөнхий боловсролын 26 сургууль, 36 цэцэрлэгийн суралцагчид Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаалаар батлагдсан түр журмын дагуу 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн танхимын сургалтад хамрагдсан. Сургуулийн сурагчдын танхимын ирц 92 хувь, цэцэрлэгийн танхимын ирц 85 хувьтай байсан.

### **Элсэлтийн шалгалтын бэлтгэл:**

Ерөнхий боловсролын 18 сургуулийн 12 дугаар ангийн 798 сурагчаас Элсэлтийн ерөнхий шалгалтын 10 хичээлээр гарааны үнэлгээ авч, анализ, дүгнэлт хийсэн. 12 дугаар ангийн сурагчдын дунд сурагч багш арга хэмжээнд 23 сургуулийн 170 гаруй сурагчид идэвхтэй оролцлоо. Бусдад өөрийн мэдлэг, чадвараа хуваалцсан суралцагчдыг хүлээн авч тэдний саналыг сонсч, талархал гардуулав. Цагаан-Овоо, Чойбалсан сумын 12 дугаар ангийн сурагчдад элсэлтийн ерөнхий шалгалтын 5 хичээлээр эрчимжүүлсэн сургалт зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.

### **Сургалт, зөвлөмж дэмжлэг:**

Халхгол сумын сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, ковидын үеийн нөхцөл байдалтай танилцан, цаашид анхаарах асуудалд үүрэг, чиглэл өгсөн.



Зөвлөх болон Тэргүүлэх зэрэгтэй багшийн манлайллыг нэмэгдүүлэх үүднээс “Багш зөвлөж байна” сэдвээр багшийг чадваржуулах, арга зүйд дэмжлэг болгох ажлуудыг зохион байгуулав. Хэрлэн сумын 1, 11, 12, Баяндун, Дашбалбар сумын сургуулийн сургалтын менежерүүд цахим зөвлөмж, зайн сургалт, бүлгийн ярилцлагыг 3 дугаар сарын 5-ны өдөр 1-5 дугаар ангийн бүлэгт Онлайн орчинд зохион байгуулав.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүүхдийг ивээх сангаас Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжилтнүүдэд зохион байгуулсан “Багш нар хүүхэдтэй эерэг аргаар харилцах арга зүй” сургалтыг цэцэрлэгийн арга зүйч нарт зохион байгуулсан. Сургалтад цэцэрлэгийн арга зүйч, заах аргын нэгдлийн ахлагч 35 хүн оролцлоо.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер, нийгмийн ажилтнууд болон цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарт “Хүүхэд хамгаалал ба нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө” мэдээллийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг зэрэг байгууллагын мэргэжлийн сэтгэл зүйч нараар арга зүйн дэмжлэг үзүүлэв.

Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсны 90 жил, Боловсрол, шинжлэх ухааны салбар үүсч хөгжсний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Математикийн түргэн бодолтын уралдаан”-д аймгийн ерөнхий боловсролын 24 сургуулийн 6-12 дугаар ангийн 564 суралцагчид оролцов.

#### **Эрдэм шинжилгээний хурал:**

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан болон цэцэрлэгийн эрхлэгч арга зүйч нарын дунд Ковид-19 цар тахлын үеийн боловсролын үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудал, шийдэл, арга зам сэдэвт онол, практикийн хурал зохион байгуулав.

#### **Соёлын үйл ажиллагаа:**

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт тухайн сумын соёлын биет бус өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлд хамруулах, бүртгэл мэдээллийн ажлыг эрчимжүүлэх, аймгийн бүртгэл мэдээллийн санд эрхзүйн хүрээнд бүртгүүлэх чиглэл хүргүүлээд байна.

Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Соёлын биет бус өвийн бүртгэл” цахим сургалт зохион байгуулагдав.

Соёлын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан соёл урлагийн салбарын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр чадавхижуулах цахим сургалт зохион байгуулагдав.

Аймгийн Хөгжимт драмын таетрын уран бүртээлчдийн ур чадварын түвшин тогтоох шалгалт 3 өдрийн туршид явагдаж дууссан.

**Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар**

***“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:***

Хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 14 дуудлага, өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн бөгөөд шийдвэрлэлт 70 хувьтай байна. “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө”-өөр нийт 11 хүүхэд 16 удаагийн давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авахаас гадна өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй ба цахим зохистой хэрэглээ сэдвээр 22 хүүхдэд сургалтад хамруулж, зөвлөмж, мэдээлэл хүргэсэн. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д тайлант сард 8 хүүхэд 1 насанд хүрэгчийг хүлээн авч, хамгаалан байрлуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг шуурхай хүргэсэн. Эрх нь зөрчигдөж, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 1 хүүхдийн шүүх хурлын урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохоос гадна 1 хүүхдийн эрхийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 1 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож хүүхдийн эрхийг хангахаас гадна Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үрчлэлтийн дүгнэлт гаргуулах саналын хүрээнд 3 өрхөд үнэлгээ хийж, дүгнэлтийг хүргүүлсэн.

***Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:***

Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хурлыг зохион байгуулснаар гишүүд хорооны 2020 оны ажлын гүйцэтгэлтэй танилцаж, 2021 оны төлөвлөгөөг хэлэлцэн батлахаас гадна хурлаар эрсдэлт нөхцөл дэх хүүхдүүдийн кейстэй танилцан холбогдох шийдвэрүүдийг гаргав. Мөн уг хуралд Хүүхэд хамгаалал төвийн тэргүүн цахимаар оролцож, хорооны гишүүдийн чиг үүргийн талаарх ойлголт мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх сургалт, мэдээллийг өгөв.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах”, тусламж дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд “Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу шуурхай штабыг байгуулан 70584455 утсаар дуудлага, мэдээллийг өдөр бүр тогтмол хүлээн авч хариу үйлчилгээг тогтмол үзүүлж байна. аймгийн Цагдаагийн газар, Хүүхдийн эрхийн улсын байцаагчидтай хамтран “Хүүхэд хяналт” арга хэмжээг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд тайланд сард 2 удаагийн эргүүл хяналтыг зохион байгуулснаар аймгийн төвд амьдарч буй 2020 онд үрчлэгдсэн 22 хүүхэд болон бэлгийн хүчирхийллийн хохирогч 8 хүүхдийн ар гэрт эргэн хяналт хийж, нөхцөл байдалтай танилцсан. Мөн хяналт шалгалтаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг илрүүлэх зорилгоор аймгийн төвийн ойролцоо байрлах хурдан морины 13 зүчээгээр явж, нөхцөл байдалтай танилцснаар сургууль завсардсан 3 хүүхдийг илрүүлэн нэг цэгийн үйлчилгээний төвд 2 хүүхдийг хүлээн авч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай үзүүлсэн.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2016 оны А/330 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх” журмын дагуу магадлан итгэмжлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад албан бичгийг хүргүүлээд байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Сургууль ба охидын үзлэг” хэлэлцүүлгийг зохион байгуулж, оролцогчид “Охидын үзлэг”-ийг ямар зорилгоор зохион байгуулдаг, түүний хэрэгцээ, зорилгодоо нийцэж буй эсэх, түүнээс гарч буй сөрөг үр дагавруудын талаар санал солилцов. Мөн Дорнод аймагт өсвөр үеийн хүүхэд, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн нөхцөл байдал, насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлтийн талаарх статистик тоон мэдээлэлтэй танилцаж, дүгнэлт хэлэлцүүлгийг өрнүүлэв. Хэлэлцүүлэгт аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эмч, ерөнхий боловсролын сургууль, Дорнод Их сургууль, Политехникийн коллежийн сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, эмч нар, хүүхэд, залуучуудын төлөөлөл нийт 22 хүн оролцов.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалах өдрийн хүрээнд “Орон нутгийн эмэгтэйчүүдийн нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх” зорилгоор онлайн уулзалтыг зохион байгуулж, уулзалтад аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь эмэгтэй Төлөөлөгчид, эмэгтэйчүүдийн сүлжээ төрийн бус байгууллагууд, эмэгтэйчүүдийн аймаг, сумдын зөвлөл, нийгмийн ажилтнууд зэрэг 50 эмэгтэйг хамруулан орон нутгийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаарх үр дүнтэй хэлэлцүүлгийг өрнүүлэв.

Мөн “Гэргийдээ захидал бичээрэй” захидлын уралдааныг 2 дахь жилдээ зохион байгуулж, албан байгууллага, иргэд, хугацаат цэргийн алба хаагч залуусын илгээсэн 45 захидлыг хүлээн авч, 5 шилдэг захидлыг тодруулан, нэвтрүүлэг бэлтгэн, гарын бэлгийн хамт захидлыг эздэд нь хүргэсэн.

Аймгийн засаг даргын “Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай” 2021 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжилтийг хангах хүрээнд сумдын хамтарсан багийн үйл ажиллагаанд зөвлөн туслах зорилгоор 2 өдрийн хугацаанд Баян-Уул суманд ажиллав. Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага, мэдээллийг шийдвэрлэх, гэр бүл, хүүхэд, багш нарт чиглэсэн ажиллагааны үр дүн, сургуулийн хүүхэд хамгаалах бодлогын хэрэгжилттэй танилцаж, цаашид анхаарах авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, сургалт арга зүйг өгөхөөс гадна хүүхдийн эрх сургуулийн орчинд зөрчигдсөн гэх 2 зөрчлийн хэрэгт ажиллаж, зөрчил шалган ажиллаж байна. Мөн Гэр бүлийн туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 8 өрхөөр сумын нийгмийн ажилтан, багийн Засаг даргын айлчлан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, гарын авлага, зөвлөмжүүд хүргүүлж, насанд хүрэгч 1 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөв.

### ***Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:***

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучуудад тогтмол зохион байгуулж байна. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны 2 хүүхэд, Хилийн цэргийн 0132 дугаар ангийн үйлчилгээний 20 ажилчин албан хаагч, “Dornod volunteers” клубын 12 гишүүн, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж байгаа 8 үйлчлүүлэгч, Цагдаагийн газрын эрүүлжүүлэн саатуулах байранд хоригдож байгаа 40 иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын аж ахуйн үйлчилгээний 3 хоригдол, хөгжлийн бэрхшээлтэй 15 өсвөр үе, залуучууд зэрэг нийт 97 хүнд амьдрах ухааны сургалтыг зохион байгуулав.

“Good deeds day” /Сайн үйлсийн өдөр/ аяны хүрээнд 6 төрлийн ажлыг төлөвлөн аж ахуйн нэгж, албан байгууллагуудад удирдамж, албан тоотыг хүргүүлж, байгууллага, гэр бүл, найз нөхдөөрөө нэгдэн нэг өдрийг хүрээлэн буй орчноо сайжруулах, нийтэд ашиг тустай ажил зохион байгуулахыг уриалж, мэдээллийг түгээв.

Сайн дурын залуучуудыг бэлтгэх “Dornod Volunteers 2” клубын үйл ажиллагаа тогтмолжиж клубын гишүүдийг чадавхжуулах сургалтыг “Илтгэх урлаг”, “Мэргэжил сонголт”, “Өөртөө итгэх илтгэл” сэдвүүдээр зохион байгуулав. Мөн “Спортын өдөрлөг”, “Өөрөө өөртөө тогооч” зэрэг олон талт үйл ажиллагаа зохион байгуулж, чадавхжуулав. Мөн “Dornod Volunteers” клубын гишүүд “Шинэ үеийн илгээлтийн эзэд” үйл ажиллагаагаар Баянтүмэн сумын 3 өрхөд хаврын бэлтгэл ажилд туслах, малын хашаа, саравч цэвэрлэх, засварлах зэрэг хүний хүч шаардах ажлыг хийж сайн дурын үйл ажиллагааг хүргэсэн бөгөөд сайн дурын 14 өсвөр үе, залуучууд оролцож, 2 багт хуваагдан ажиллав.

Хүүхэд залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Global Money Week” Олон Улсын аяныг Монгол Улс 7 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд иргэд олон нийт, хүүхэд, залуучуудад санхүүгийн боловсрол болон хуримтлалын ач холбогдол, “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын дэглэмийг чандлан баримтлах чиглэлийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэсэн.

### ***Мэдлэг чадвараа дээшлүүлэх хүрээнд:***

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албан хаагчдын хандлага, соёл, ур чадварыг өөрчлөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр цуврал сургалтуудыг Канадын “MERIT” төсөлтэй хамтран зохион байгуулсан “Харилцан хүндэтгэл итгэлцэл бүхий орчныг бүрдүүлэх нь”, “Өөрчлөлтөд дасан зохицож удирдах нь” зэрэг 2 багц сургалтад албан хаагчдыг хамруулан чадавхжуулсан.

“Байгууллагын соёлыг бэхжүүлж, албан хаагчдын ёс зүйн манлайллыг дээшлүүлэх” зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд 2 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж, гарч буй шинэ соргог мэдээ, мэдээллийг цаг алдалгүй солилцох, харилцан бие биеэсээ суралцах зорилтыг дэвшүүлээд байна.

### ***Хэвлэл мэдээллийн хүрээнд:***

Цахим хуудсаар эцэг эх, хүүхэд, залуучуудад зориулсан 26 төрлийн мэдээллийг тогтмол түгээж, 20000 хандалт авсан бөгөөд сар бүрийн үйл ажиллагааны талаарх нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд сурталчилж байна.

### ***Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс***

#### **Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:**

Нийгмийн даатгалын санд 2021 оны 03 дугаар сард 2345251,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2535924,3 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 108,1 хувиар биелүүлсэн байна. 2021 оны 03 дүгээр сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийн даатгалын сангийн орлого /мянган төгрөг/

№	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	2028072,4	2206542	108,8
2	Тэтгэмжийн даатгалын санд	153995,6	168471,1	109,4
3	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд	132453,4	130334,2	98,4
4	Ажилгүйдлийн даатгалын санд	30729,8	30577	99,5
	Нийт	2345251,2	2535924,3	108,1

Нийгмийн даатгалын ерөнхий газраас тэтгэврийн санд нийт 3600000,0 мянга, тэтгэмжийн санд нийт 100000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан.

2021 оны 03 дугаар сард нийт 541 ажил олгогч байгууллагын 307,2 сая, 1566 сайн дурын даатгуулагчдын 70,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс (Тэтгэврийн даатгалын 8,5 хувь, Эрүүл мэндийн даатгалын 2 хувийн шимтгэлээс бусад) тус тус чөлөөлсөн байна.

#### **Хоёр. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:**

Аймгийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сард шинээр нийт 90 иргэнд тэтгэвэр тогтоосон.

Түүнчлэн 2021 оны 03 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас:

- Өндөр нас 9291,
- Тахир дутуу 2798,
- Тэжээгчээ алдсан 622,
- Цэргийн тэтгэвэр 619, нийт 13330 тэтгэвэр авагчдад 20981094,2 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

**Гурав. Тэтгэмж олголтын талаар:**

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 182,
- Жирэмсэн амаржсны тэтгэмж 119,
- Оршуулгын тэтгэмж 34 даатгуулагчид, нийт 314864,4 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

**Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:**

Аймгийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сард нийт 114 даатгуулагчдад 54878,2 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов.

**Тав. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:**

Уг сангаас 76 тэтгэвэр авагчдад нийт 35352,08 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

**Зургаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:**

2021 оны 03 дугаар сарын байдлаар 1278767,7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагатай байна. Үүнээс 185 аж ахуйн нэгж, байгууллагын 1046385 мянган төгрөг, 29 төсөвт байгууллагын 232381,9 мянган төгрөгийн өр, авлага үүсгэсэн байна.

### **Долоо. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа:**

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс 4 удаа хуралдаж, 264 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 13 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 220 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан. 24 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна. Ковид-19 цар тахал ихэссэнтэй холбоотойгоор Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссийн хурлыг цахимаар зохион байгуулж байна.

2021 оны 03 дугаар сард нийт 7 иргэний амбулаторийн картыг магадлаж, шинжилгээний бүрдэл дутуу, оношийн үндэслэл хангалтгүй, заалт тохирохгүй шалтгааны улмаас 2 картыг буцаах арга хэмжээ авав.

Түүнчлэн комиссын хурлаар орж буй иргэдийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үндэслэлд хяналт тавьж, онош заалт тохирохгүй, оношийн үндэслэл хангалтгүй, шинжилгээний бүрдэл дутуу зэрэг шалтгааны улмаас 7 иргэний Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлэх арга хэмжээ авлаа.

### **Ес. Дотоод ажил, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр:**

2021 оны 03 дугаар сард үдийн цайны цагаар 198 иргэнд, 4098 хүнд угтах үйлчилгээг үзүүлсэн. Түүнчлэн нээлттэй утас 7058-5955 дугаарт хандсан 251 иргэн даатгуулагчид зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Архиваас 40 даатгуулагчид лавлагаа олгохоос гадна бусад 5 аймаг, дүүргийн 5 иргэнд лавлагаа олгож, тэдний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажууллаа.

Мөн 2006 оноос хойших “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт” програмыг ашиглаж, дахин давтагдашгүй тоон өгөгдөл бүхий QR кодтой лавлагааг 26 иргэнд түргэн шуурхай чирэгдэлгүй олгосон.

Иргэд, даатгуулагчидад нийгмийн даатгалын сайн дурын даатгалын талаарх мэдээллийг цахим хуудас болон орон нутгийн “Мижиг”, “Дорнод” телевизүүдээр хүргэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд 10 байцаагч ажилтныг хамруулсан. Мөн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын болон тэтгэврийн дэвтрийг цахимд шилжиж байгаатай холбоотой 3 дугаар сард 3084 иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын аппликэйшнийг баталгаажуулсан байна.

***Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар***

### **Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ:**

#### **Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:**

Өнгөрсөн 3 дугаар сарын байдлаар 1259 ажил хайгч иргэн бүртгэлтэй байгаагаас 384 буюу 30 хувь эмэгтэй ажил хайгч байна. Үүнээс боловсролгүй 25, бага боловсролтой 25, суурь боловсролтой 66, бүрэн дунд боловсролтой 773 тусгай, техникийн боловсролтой 181, дээд боловсролтой 184 иргэн тус тус бүртгэлтэй байна.

#### **Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сэтгэл зүйч “Хувь хүний төлөвшил”, “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох”, “Мэргэжил бүхэн сайхан” сэдэвт зөвлөгөө, мэдээлэл өгөх сургалтыг 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 20 сурагч хамрагдсан.

#### **Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:**

Өнгөрсөн сард 40 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс 85 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлснийг ажил идэвхитэй хайж байгаа иргэдэд санал болгож, 70 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсны 28 буюу 35,8 хувь нь эмэгтэй байна. Салбар тус бүрээр нь авч үзвэл менежер, контор, үйлчилгээний ажилтан 31, техникийн 8, хөдөө аж ахуй 10, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 21 иргэн тус тус зуучлагдсан байна.

#### **Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр:**

Аймгийн Засаг даргын 2021 оны А/01 дүгээр захирамжаар “Хувийн хэвшлийг дэмжих жил” болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулсан 4 удаа “Эртэч уулзалт”-ыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд хамрагдсан 75 иргэн хамрагдаж, холбогдох мэдээлэл, зөвлөгөө өглөө.

Уулзалтаар:

- Ажилд орох өргөдөл CV анкет хэрхэн бөглөх вэ?
- Харилцаа хандлага гэж юу вэ?
- Өөрөө өөртөө ажлын байр хэрхэн бий болгох? талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Арга хэмжээний үеэр нийт 6 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, ажилтай болгосон.



### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:**

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн зөвлөл хуралдаж, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны төлөвлөгөөг хэлэлцэж, “Эрсдлийн үнэлгээ хийх удирдамж” боловсруулаад байна.

Мөн Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны 2/714 дугаартай албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга Ш.Ёл “Эрсдлээс урьдчилан сэргийлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэе” уриан дор сарын аяны нээлтийг 14 сум 11 багтай цахимаар холбогдож, сарын аяныг танилцуулсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны А/05 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, “Хүний хөгжлийн ордон” болон “Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төв”-д “Эрсдлийн үнэлгээ” хийж, спорт заалны агааржуулалтыг нэмэх, бүх албан хаагчдыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамруулах, үйлчилгээний ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч хэвшүүлэх, тэмдэг тэмдэглэгээг хийх, анхан шатны тусламжийн өрөөг ашиглах журам зөвлөмжүүдийг гаргасан.

### **Албан бус хөдөлмөр эрхлэлт:**

“Албан бус салбарт хөдөлмөр эрхлэлт” төслийн хүрээнд Судалгаанд хамрагдсан 50 иргэнийг Политехникийн коллежтой хамтран мэргэжлийн сургалтад хамруулаад байна. Үүнээс эрэгтэй 21, эмэгтэй 29 иргэн хамрагдаж, Тогоочийн сургалтад 11 хүн, гагнуурын сургалтад 18 хүн, няравын сургалтад 21 хүн тус тус хамрагдсан.

### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 1552 иргэн хамрагдаж, 441,2 сая,
- Асаргааны тэтгэмжид 1370 иргэнд 122,2 сая,
- Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 249 иргэнд 69,7 сая,
- Жирэмсэн эхийн тэтгэмж 712 иргэнд 26,2 сая,
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4088 иргэнд 195,5 сая,
- Ихэр хүүхдийн тэтгэмж 1 иргэнд 2 сая,
- Өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж 330 иргэнд 129,9 сая,
- Ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 9 иргэнд 970 мянга,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 263 иргэнд 15,2 сая,
- Насны хишиг 21 иргэнд 1,1 сая,
- Эхийн алдар одон 13 иргэнд 1,6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр:**

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, тулгалтаар мэдээлэл зөрүүтэй гарсан 105 өрх аймгийн хэмжээнд байна. Үүнээс Хэрлэн сумын 83

өрхтэй утсаар холбогдож, холбогдох баримтыг авчран зөрүүг завсарлуулах талаар мэдэгдсэн. Мэдээллийн зөрүүг холбогдох баримтаар засварлуулсан 32 өрхийн оноог бодуулсан. Өрхийн нэгдсэн мэдээллийн санд 2021 оны 3 дугаар сард судалгаанд хамрагдах 12 өргөдөл, хүүхдийн мөнгөний 68 өргөдөл болон Иргэний эрүүл мэнд даатгалын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцаа хүссэн иргэн өргөдөл гаргасан байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдахаар шинээр 122 хүүхэд хүсэлт гаргаж, бүртгүүлсэн байна.

### **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмын дагуу магадлан итгэмжлэгдэх, хугацаа сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын жагсаалт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2021 оны А/31 дүгээр тушаалаар батлагдан гарсан. Иймд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настны үйлчилгээ үзүүлэх эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн байгууллагын дунд сонгон шалгаруулалтыг зарлаж, нийт 11 байгууллагад урилга хүргүүлээд байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс өнгөрсөн 3 дугаар сард 1 удаа хуралдаж, 6 хүүхдийн асуудал хэлэлцэн 1 хүүхдийг байнгын асаргааны тэтгэмжид шинээр хамруулж, 5 хүүхдийн байнгын асаргааг сунгасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбооны дэргэдэх “Алтанзул” хүүхэд, хөгжил төвийн 2021 оны үйл ажиллагааны чиглэлийг танилцуулах өдөрлөг 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдлаа. Өдөрлөгийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, тэгш хүртээмжтэй боловсролын таатай орчинг бий болгох замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, хөгжих, хамгаалуулах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоцрогдлыг эрт илрүүлж, бага насанд нь хөгжлийн дэмжлэг хөтөлбөрт хамрагдах боломжийг бүрдүүлэх, оюуны ялгаатай чадвартай залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх зорилтыг тавин ажиллаж байгаа талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудтай хамтран эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэв.

Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал хөтөлбөр”-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал авахаар 7 байгууллагад албан бичгээр хүргүүлээд байна.

### **Хүнс, тэжээлийн дэмжлэг, туслалцааны чиглэлээр:**

Дорнод аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2244 өрхийн 6577 том хүн, 5997 хүүхэд, нийт 12574 хүнд хүргэж, 461,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс Хэрлэн сумд 1763 өрхийн 5222 том хүн, 4707 хүүхэд, нийт 9929 иргэнд 363,2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.

### **Ахмад настны чиглэлээр:**

Сэтгэл зүйч О.Энхмэнд “Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний газар”-ын ажилтан, албан хаагчдад сэтгэл зүйн анхан шатны мэдлэг олгох 2 удаагийн сургалтаар харилцаа, хандлага гэсэн сэдвийн хүрээнд зохион байгуулж байна. Сургалтад хамрагдснаар албан хаагчид ажлын байран дээрээ стресст өртөхгүй байх, сэтгэл санааны хөнгөн гутралд орохгүй, зүрх, судасны өвчлөлөөс өөрийгөө сэргийлэх чухал ач холбогдолтой юм. Цаашид асруулагч нарт хандсан хөгжлийн үйлчилгээ үзүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/143, 2020 оны А/483 дугаар захирамжуудын хэрэгжилтийг хангах, үйл явцыг үнэлэх, үр дүнг дүгнэх, сайжруулах чиглэлээр Хэрлэн ахмадын Зөвлөлийн дарга нарын байр суурийг сонсч, “Ахмадын сан” болон харъяалалгүй байгаа ахмадуудыг аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуцуулан харъяалуулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллахаар болов.

“Ахмадын настны амралт, сувиллын төв”-д амарч байгаа ахмад настнуудад аймаг, орон нутгийн зүгээс ахмад настны талаар хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, ахмадуудын сонирхсон асуултад тайлбар мэдээлэл өглөө.

### **Биеийн тамир, спортын арга хэмжээний хүрээнд:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хуваарийн дагуу 7 хоног бүр сургалт, дасгалжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн бөгөөд хүүхдүүд биеийн ерөнхий хөгжлийн 40 тоот дасгалыг хийж хэвшээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хуваарийн дагуу 7 хоногт 2 удаа дасгал хөдөлгөөнд хамрагдаж байна. Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулсан онлайн сургалт болон Тусгай олимпын хорооны онлайн сургалтад Биеийн тамирын аргазүйч П.Энхтүвшин хамрагдав.

### **Зүүн бүсийн ахмад настны, асрамж үйлчилгээний төв:**

Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төв 2021 оны 03 дугаар сард Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу тогтмол хийж, ахмадуудад маск зүүлгэж, гарын ариун цэврийг сайтар сахиулж, гар ариутгагчийг тогтмол хэрэглүүлэн, 2 цаг тутам ахмадуудын өрөөний салхивчийг нээж агаарын солилцоо хийн, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Ахмадуудыг ковидоос урьдчилан сэргийлж, нэн шаардлага гараагүй тохиолдолд гадагшаа гаргахгүй, байгууллага дээр гадны хүмүүс орохыг хориглосон.

Нийгмийн ажилтны зүгээс ахмадуудад хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үйлчлүүлэгчдийн дунд хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн уралдаан зохион байгуулсан. Ахмадууд чөлөөт цагаар бусаддаа ерөөл айлдах, номын сангаар үйлчлүүлж, өөрсдийн сонирхсон номоо унших зэргээр чөлөөт цагийг өнгөрүүлж байна. Мөн ахмадуудтай хамтран “Сэтгэлийн илгээмж” модыг хийсэн.

“Нью-Эндорфин” эмнэлэгтэй хамтран “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэг, оношилгоо, шинжилгээ”-нд үйлчлүүлэгч ахмадуудыг хамруулав.

### **Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг** **Эрүүл мэндийн газар:**

Энэ оны эхний 03 сарын байдлаар 433 эх амаржиж, 437 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрөлт 107 тохиолдлоор буурсан, амбулаториор 100902 хүн үзлэг хийлгэж, 4165 хэвтэн эмчлүүлсэн байна.

Осол, гэмтлийн өвчлөл, нас баралтын мэдээг сар бүрийн 5-ны дотор авч нэгтгэн Гэмтэл согог судлалын үндэсний тандалт, мэдээллийн албанд тогтмол мэдээлж байна. Сар бүрийн мэдээнд өгсөн осол, гэмтлийн шинэ тохиолдлын тоог Hinfo v3.0 программд шивэгдсэн тоотой тааруулан алдааг тухай бүр залруулан хянаж байна. Төрийн өмчийн 18 эмнэлэг, хувийн хэвшлийн 28 эмнэлэг, эмийн сан 29, нийт 75 газрын үйл ажиллагааны мэдээг нэгтгэн, дүгнэлт хийж, 5 жилийн дундаж үзүүлэлт болон өмнөх оны мөн үетэй харьцуулж, 24 нүүр бүхий эрүүл мэндийн болон эмнэлгийн статистик эмхэтгэл бэлтгэн сар бүрийн 5-ны өдөр, холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, хэрэглэгчдийг мэдээллээр хангасан. “Дорнод” сонинд Зам тээврийн осол, гэмтэл болон түлэгдлийн талаар мэдээлэл бэлтгэн нийтлүүсэн. Эрүүл мэндийн сайдын 139 дугаар тушаалын дагуу 7 хоног бүрийн Мягмар гарагт улсын 17 байгууллагаас эх, хүүхдийн мэдээг tandalt.ehemut.mn цахим хаягаар авч, тогтмол хянаж байна.

Эмчлэх, сувилах, эм барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан 11 эмнэлгийн мэргэжилтний материалыг бүрдүүлэн эрүүл мэндийн хөгжлийн төвд, олон жил үр бүтээлтэй тогтвор суурьшилтай ажилласан 3 эмч, эмнэлгийн мэргэжилтний ажил байдлын тодорхойлолтыг бүрдүүлэн эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтны цол тэмдгийн шагналд тодорхойлж, Эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлсэн.

Улаанбаатар хот болон бусад аймгуудаас 2021 оны 03 дугаар сарын 01-ээс 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд Хөлөнбуйр сумын постоор Дорнод аймаг руу 2784 тээврийн хэрэгсэл, 6494 эргэн орж ирсэн. Үүнээс гэрийн тусгаарлан ажиглалтын хугацаа дууссан 6019, буцсан 77 иргэн байна. 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар 398 (Хэрлэн суманд 281, сумдад 117) иргэн гэрийн тусгаарлан ажиглалтад байна.

2021 оны 03 дугаар сарын 01-31-ний өдрүүдэд 5369 иргэдэд төрийн байгууллагуудтай хамтран халдварын хяналт, сэргийлэлт, тандалтыг утсаар болон цахимаар хийж, тандалтын явцад илэрсэн зөрчлийг мэргэжлийн байгууллагад мэдээлэн шуурхай хариу арга хэмжээ авч байна.

Халдварын голомттой бүс нутгаас ирж буй иргэдэд 72 цагийн доторх PCR шинжилгээтэй, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 20 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын 2.1.3 халдварын голомтот бүс нутгаас ирсэн иргэн гэрийн тусгаарлалтад 7 хоног, 2,2 гэрийн тусгаарлалтад орсон иргэний гэр бүлийн гишүүдийг гэрийн тусгаарлалтад байх хоногоор хамт тусгаарлан 7-14 хоногийн дэглэм мөрдүүлж, 7 дахь хоногт давтан шинжилгээг авч сэжигтэй болон шинж тэмдэг илэрсэн тохиолдлуудыг тусгаарлан PCR шинжилгээнд хамруулж байна. Өнөөдрийн байдлаар 2195 иргэн давтан шинжилгээндээ хамрагдсан байна.

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан Нийгмийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сүрьеэгийн тасаг, Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн сайн дурын ажилтнууд хамтран “Дорнод худалдаа” ХК, “Шүр” захын түрээслэгчдэд сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, гарын авлага, маск түгээв.

Эрүүл аж төрөх зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн 4 тэмдэглэлт өдрүүдийг орон нутгийн 2 телевиз, Эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн төвийн зөвлөгөө өгөх цахим хуудсанд байршуулан олон нийтэд сурталчилсан.

“Дорнод Нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 170 орчим албан хаагч нарт “Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйлийг иргэдэд төлөвшүүлэх”, “Хөдөлмөрийн эрүүл ахуй түүнд тавигдах шаардлага”, “Мэргэжлээс шалтгаалах өвчний тухай ойлголт урьдчилан сэргийлэх арга зам”, “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

**Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

**МАЛ АЖ АХУЙ:**

**Хаваржилтын бэлтгэл ажлын талаар:** Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцэст 5650 малчин өрхөд 2,749,027 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 6.1 сая толгой мал хаваржиж байна. Өмнөх онтой харьцуулахад 83344 толгой буюу 4,3 хувиар өссөн дүнтэй байна.

2020 онд нийт 1,233,963 толгой хээлтэгч мал тоолуулснаас 2021 онд 1,043,356 толгой буюу нийт хээлтэгчийн 84.5 хувь нь төллөх төлөвлөгөөтэй байна.

**Төл бойжилт:** 1043356 толгой төллөх хээлтэгчээс 61676 толгой буюу 5.9% нь төллөж 359 төлийн хорогдолтой буюу 99.4 % нь эсэн мэнд бойжиж байна.

№	Төрөл	Гарсан төл	Төлийн хорогдол	Бойжиж буй төл	Хувь
1	Ботго	176	0	176	100
2	Унага	2458	22	2436	99.1
3	Тугал	5648	24	5624	99.6
4	Хурга	35195	147	35048	99.2
5	Ишиг	18558	166	18392	98.5
<b>Нийт</b>		<b>62035</b>	<b>359</b>	<b>61676</b>	<b>99.4</b>

**Том малын зүй бус хорогдол:** 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар: Том малын зүй бус хорогдол 3199 толгой буюу нийт малын 0,12 хувийг эзлэж байна. Үүнээс: Адуу 100 толгой буюу 0.03 хувь, үхэр 361 толгой буюу 0.12 хувь, хонь 1263 толгой буюу 0.01 хувь, ямаа 1475 толгой буюу 0.2 хувь мал хорогдсон байна.

**Ноолуур бэлтгэл:** Аймгийн хэмжээнд 810850 толгой ямаанаас дунджаар 283,8 тонн ноолуур бэлтгэж 42.5 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой байна. Зах зээлийн ханш 150.000 төгрөг байна.

Аймгийн хэмжээнд 18 иргэн, аж ахуйн нэгж ноолуур бэлтгэх, худалдан авах газрын байршил өгсөн байна. Улаанбаатар хотоос манай аймагт 15 иргэн ноолуур бэлтгэх, худалдан авахаар бүртгүүлээд байна.

**Аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн зарцуулалт, үлдэгдэл:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2021 оны өвөлжилт, 2021 оны хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулах 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөл	Бэлтгэсэн /тн/		Зарцуулсан /тн/		Үлдэгдэл /тн/			
	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Хувь	Тэжээл	Хувь

Аймгийн аюулгүйн нөөц	199.7	53.8	0.3	29.8	199.4	<b>99.8</b>	24	<b>44.6</b>
Сумын аюулгүйн нөөц	1412.6	363.8	937.6	298.9	475.0	<b>64.9</b>	64.9	<b>17.8</b>
Малчдын түвшинд бэлтгэсэн	92206	333.8	67545.9	284.1	24659.9	<b>49.7</b>	49.7	<b>14.8</b>

**Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл борлуулалт:** Аймгийн аюулгүйн нөөцийн өвс 0.3 тонн, хивэг 29.8 тонныг борлуулж аймгийн Мал хамгаалах сангийн 100070051402 дансанд 13.123.000 төгрөгийг төвлөрүүлээд байна.

№	Нийлүүлсэн ААН, байгууллага	Малын тэжээлийн нэр төрөл	Хэмжээ /боодол/	Хэмжээ /тн/	Борлогдсон хэмжээ /тн/	Үлдэгдэл /тн/	Борлуулж буй үнэ
1	"Сарнайн туяа" ХХК	Байгалийн хадлангийн өвс	8630	172.6	0.3	172,3	<b>3300</b>
2	"Дорнод гурил" ХХК	Хивэг	1373	34.3	29.8	4,5	<b>11000</b>
3	"Дорнын тал" ХХК уудам	Ногоон тэжээл	1085	27.1	0	27,1	<b>9500</b>
4	"Тасу Бридж" ХХК	Жижиглэсэн ногоон тэжээл	780	19.5	0	19,5	<b>13000</b>
<b>НИЙТ</b>			<b>Өвс</b>	<b>199,7</b>	<b>0,3</b>	<b>199,4</b>	-
			<b>Тэжээл</b>	<b>53,8</b>	<b>29,8</b>	<b>24</b>	-

**Отроор өвөлжиж байгаа, шилжиж ирсэн малын судалгаа:** Аймгийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотын 2 дүүрэг болон 10 аймгийн 22 сумын 103 өрхийн 64069 толгой мал отор нүүдлээр 10 суманд ирээд байна.

2020 онд оны 12 дугаар сарын 03-ны байдлаар Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Чойбалсан, Халхгол, Матад 5 суманд Улаанбаатар хотын 1 дүүрэг, 6 өөр аймгийн 19 сумаас 29 өрхийн Адуу 2971 толгой, Үхэр 1023 толгой, Хонь 4213 толгой, Ямаа 5169 толгой нийт 13376 толгой мал шилжиж ирсэн байна.

ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2020 оны 63 дугаар хурлын тэмдэглэлд 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор чөлөөлүүлэх зохицуулалтын арга хэмжээний хүрээнд аймгийн ИТХ-ын 2021 оны 10 дугаар тогтоолоор байгуулагдсан "Отор, нүүдэл шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах" ажлын хэсэг 10 сумын 20 өрхтэй газар дээр нь отор, нүүдлийн талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.





**Ноолуурын гарц, чанарын үзүүлэлт тодорхойлох ажлын хүрээнд:**

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол “Ноолуур” хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Дорнод аймгийн мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн

газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн баталсан удирдамж, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн баталсан арга аргачлалын дагуу “Ноолуурын гарц, чанарын үзүүлэлт тодорхойлох” ажлыг 2021 оны 03 дугаар сарын 10-25-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Тус ажлын хүрээнд 12 сумын 38 багийн 186 малчин өрхөөс 1652 ноолуурын дээжийг авч, 1502 толгой ямааг ээмэгжүүлэн, биеийн үндсэн хэмжилт, хаврын амьдын жин, ноолуурын бохир гарцыг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэлээ.

**Ноолуур худалдан авалтад хяналт тавьж ажилласан тухай:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2021 оны 16 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын орлогч, аймгийн онцгой комиссын орлогч даргын баталсан коронавируст халдвар /Covid-19/-т цар тахлын үед ноолуур худалдан авахаар Улаанбаатар хотоос ирсэн иргэдийн тусгаарлалт, ноолуур худалдан авалтад хяналт тавих ажлын удирдамжаар аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хэрлэн сумын ЗДТГ-ын нийт 6 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ноолуур бэлтгэн, худалдан авч байгаа 16 цэгийн иргэн, аж ахуйн нэгжид коронавирус халдвар /COVID-19/-т цар тахлаас урьдчилан сэргийлж, улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комисс, мэргэжлийн байгууллагын гаргасан заавар зөвлөмж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, хүний бөөгнөрөл үүсгэхгүй, ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

**“Малчид, малчдын хоршоодод зориулсан түүхий эд бэлтгэлийн чиглэлээр шаталсан сургалт”-ыг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа:** Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018

оны 47 дугаар тогтоол “Ноолуур” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021 оны “Хувийн хэвшлийг дэмжих жил” 01 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагаан-Овоо, Баян-Уул, Дашбалбар сумын хоршооны малчдад “Ноолуур ангилан бэлтгэгч” чадамжид суурилсан сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 2-18-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтад Цагаан-Овоо сумын “Дорнод Галуут”, “Элст Цагаан тэмээт” хоршооны 62 малчин эмэгтэй, Баян-Уул сумын “Улзын арвин сүрэг”, “Номгоной гол” хоршооны 28 малчин эмэгтэй, Дашбалбар сумын “Үүрийн толан” хоршооны 30 малчин эмэгтэй нийт 3 сумын 120 эмэгтэйчүүд хамрагдлаа

### ГАЗАР ТАРИАЛАН:

**Төлөвлөлт:** Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮЯамны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүний нийлүүлэх гэрээгээр 23,8 мянган.га-д үр тариа, үүнээс 26,9 мянган.га-д улаан буудай, 2,1 мянган.га-д тосны ургамал, 5,5 мянган.га-д малын тэжээл 189 га-д төмс, 127 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 29,6 мянган.тн, үүнээс 26,9 мянган .тн улаан буудай, 3,8 мянган тн бусад үр тариа, 1,4 мянган.тн тосны ургамал, 2,4 мянган.тн төмс, 1,5 мянган.тн хүнсний ногоо, 11,0 мянган.тн малын тэжээл, 1,4 мянган тонн тосны ургамал, 13 тн тонн жимс, жимсгэнэ тус тус хураан авч 24,1 мянган га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөн хаврын тариалалтын бэлтгэл ажилдаа ороод байна.

2020 оны төлөвлөгөө	Нийт үр тариа (га-аар)	Үр тариа таримлын төрлөөр (га-аар)				Бусад тарьмал (га-аар)				Нийт тариалах талбай (га-аар)	Уриншийн төлөвлөгөө (га-аар)
		Буудай	Арвай	Овьёос	Бусад үр тариа	Тосны ургамал	Малын тэжээл	Төмс	Хүнсний ногоо		
Тариалах талбай (га-аар)	22600	18500	300	300	3500	4500	2500	161	117	29878	25000
Га-ийн ургац (цн-ээр)	12.0	12.0	12.0	10.0	12.0	8.0	20.0	120.1	119.9		
Хураан авах ургац (тн-аар)	27060	22200	360	300	4200	3600	5000	1934	1403		

Улаан буудайн үрийн хангамжийг бүрдүүлэх зорилгоор 2020 оны ургацаас 3000 тн үрийн нөөцийг бүрдүүлсэн бөгөөд дутагдах 611 тн үрийн буудайн захиалгыг Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан авахаар төлөвлөөд байна.

**Цахим сургалт:** ХХААХҮЯ, МХЕГ, ХААИС, УГТХ-тэй хамтран зохион байгуулж буй “Таримал ургамлын сорт сорилт, үр үржүүлэг” сэдэвт онлайн сургалтад 2021.03.23-ны өдрөөс 26-ны өдрүүдэд 21 аймгийн агрономууд болон Хэрлэн, Чойбалсан, Халхгол, Дашбалбар, Баяндун, Цагаан-Овоо сумдын мэргэжилтнүүд хамрагдаж үр сорт, хөрс хамгаалах, болон бусад мэдлэг мэдээлэлийг хүлээн авлаа.

**Хаврын тариалалтын бэлтгэл хангах:** ХХААХҮЯам, Эрүүл мэндийн яамтай хамтран Улаанбаатар хотоос орон нутагт очиж ажиллах тариаланчдыг “COVID-19” эсрэг вакцинд 2021 оны 3-р сарын 26-27-ны өдрүүдэд хамруулахтай холбогдуулан

аймгийн хэмжээнд нийт тариалан бүхий 8 сумын 160 тариаланчдын судалгааг хүргүүлсэн. Үүнээс 75 тариаланч буюу 46,8 хувь нь Улаанбаатар хотод хамрагдахаас 35 нь хамрагдсан.

### **ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Зээлийн батлан даалтын сургалт, мэдээлэл:** “Best” хөтөлбөртэй хамтран “Ажлын байрыг дэмжих зээл” буюу жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай, ААН-дэд 500 сая хүртэл, иргэдэд 50 сая хүртэл төгрөгийн зээлийг олгох ажлын хүрээнд барьцаа хөрөнгийн дутагдалтай зээл хүсэгчид зээлийн дүнгийн 60 хувьд зээлийн батлан даалт гаргах талаар I Mongolia 89.1 фм-ээр болон арилжааны банкуудын эдийн засагч, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв”-д үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд сургалт мэдээлэл өгч, мэдээлэл өгч ажиллалаа

### **ХҮНС, ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:**

**Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа, үнийн мэдээ:** Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн судалгаа, нөөцийн мэдээ болон гамшгийн үеийн 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний судалгааг 14 сумаас авч 7 хоног бүрийн даваа, пүрэв гарагт ХХААХҮ-ийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хэрлэн сумын 11 багийн 34 хүнсний дэлгүүрээс гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн судалгаа авч, 11 дүгээр сарын үнийн судалгаатай харьцуулалт хийж аймгийн онцгой комисст танилцуулж ажиллалаа.

Мөн аймгийн Засаг даргын А/565 дугаар захирамж “Зарим төрлийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг хангах талаар авах арга хэмжээний тухай” түр журмын хэрэгжилттэй танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Дорнод аймгаас хилээр болон Улаанбаатар хот руу экспортолж буй бүтээгдэхүүний талаар мэдээлэл бэлдэж ХОХБТХ-г танилцуулав. **“Сүү боловсруулах үйлдвэрийн цогцолбор” байгуулах төслийн танилцуулга, уулзалт:** 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр аймгийн Засаг даргын 2021 оны А/15 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн сүү үйлдвэрлэлийн “Дэвшил холбоо” ТББ-ын “Сүү боловсруулах үйлдвэрийн цогцолбор” байгуулах төслийн эдийн засгийн үндэслэлийн мэдээлэлтэй танилцах уулзалт зохион байгуулагдлаа.

**Аж ахуйн нэгжийн нөлөөллийн судалгаа:** 2021 оныг “Хувийн хэвшлийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан мал аж ахуй, газар тариалан,

үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлийн орон нутгийн аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс коронавируст халдвар /COVID-19/-ын нөлөөллийн судалгааг авч эхлээд байна.

### **МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Мал эмнэлгийн газар нь 2021 оныг “Хамтын ажиллагаа-Цахим шинэчлэл” гэсэн зорилтот жилийн хүрээнд байгууллага аж ахуй нэгж болон хувь хүн төрийн байгууллагаас нээлтэй утас 70583370 дугаарт болон бичгээр ирсэн өргөдөл, гомдол хүлээн авч ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсвөөс санхүүжүүлэх зооноз халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг батлуулан мал эмнэлгийн цахим системд сумдын Мал эмнэлгийн тасаг төлөвлөгөөг 2020 оны гүйцэтгэлийг байршуулан ажиллаж байна.

### **Халдварт өвчнөөс сэргийлэх талаар:**

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд Булган, Сэргэлэн сумын 2 малчны суур 118 толгой мэдрэтгий үхэр, ямаан сүргийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан ажилласан

### **СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

ХХААЯам, орон нутаг, холбогдох байгууллагаас зохион байгуулсан 2 удаагийн цахим болон танхимын сургалтанд 2 албан хаагч, ажлын байран дээрх 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 40 албан хаагчийг тус тус хамруулж, хариуцсан ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэн ажилласан.

Тайлант сарын хугацаанд салбарын бодлого шийдвэрийг малчид иргэдэд танилцуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлэх зорилгоор 5 удаагийн сургалтад 145 иргэн, аж ахуйн нэгж, албан хаагчдыг хамруулж салбарын шинэ мэдээ мэдээлээр ханган ажилласан.

МЭЕГ, Швецарийн хөгжлийн агентлаг "Ногоон Алт- Малын эрүүл мэнд" төсөл, Монголын тархвар зүйчдийн холбоотой хамтран сумдын тархвар зүйч мэргэжилтнүүдэд эпидемиологийн чиглэлээр сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдөр цахимаар зүүн бүсийн аймгуудад зохион байгуулсан. Дээрх сургалтанд 14 сумын МЭТ-ийн тархвар зүйч мэргэжилтнүүд, МЭГ-ын мэргэжилтнүүд хамрагдсан.

Хамтын ажиллагаа-Цахим шинэчлэл" зорилтот жилийн хүрээнд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд зориулсан сургалтыг Мал эмнэлгийн газрын дарга Ч.Аюушмаагаар ахлуулсан ажлын хэсэг Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Сэргэлэн

сумдад зохион байгуулж, мөрдөн мөшгих тогтолцооны тоног төхөөрөмжийг гардуулан ажилласан.

## **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

### **ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АСУУДЛЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн Засаг даргаас иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх 1, иргэний гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 11, захирамжид өөрчлөлт оруулах 1, газар эзэмших эрхийг дуусгавар болгох 1, газрын хэмжээг шинэчлэн тогтоох 1, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс байгуулах 2 захирамжийг тус тус гаргасан байна.

Газрын кадастрын цахим системд газрын төлбөрийн 2021 оны ногдуулалт үүсгэн татварын удирдлагын цахим системд илгээх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа ба газрын төлбөрийн нэхэмжлэх 90 хувьтай илгээгдээд байна.

Газрын үнэлгээний системд аймгийн хэмжээнд инженерийн шугам сүлжээ дэд бүтцийг уншуулж Хэрлэн суманд 23565 нэгж талбарын хүчин зүйлийн утгыг бодуулж 978 нэгж талбарын үнийн мэдээг системд бүртгэсэн болно. Цахим бирж програмд 57 нэгж талбар бүртгэгдсэн байна.

Газрын маргааны асуудлаар иргэн Б.Батчимэг, “Магнай трейд” ХХК нарын нэхэмжлэлтэй захиргааны хэргийн шүүх хуралд хариуцагчаар оролцсон.

Газрын кадастрын мэдээллийн санд 73 иргэн аж ахуй нэгжийн кадастрын зургийн өөрчлөлтийг оруулсан.

Дундын мэдээллийн сангаар 13 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээж гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан байна. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 1/420 дугаар албан бичгийн дагуу Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд хууль тогтоомжийн дагуу тогтоосон хамгаалалтын бүс, зурвас газрын зураглалыг оруулж баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 он, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019-2020 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажилд хийх гүйцэтгэл, нийцлийн аудит, “Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх” сэдэвт аудит хийгдэж байгаатай холбоотойгоор сумдын Засаг дарга, Санхүү албаны дарга, газрын даамлуудад чиглэл өгөх цахим хурлыг зохион байгуулсан.

Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залгаа орших Дорнод аймгийн Баян-уул, Булган, Матад, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдын хилийн цэсийг шалган газар дээр нь тодотгон тэмдэгжүүлэх, малчдын хооронд үүссэн маргааныг тодорхойлж, хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг

даргын 2021 оны А/154 дүгээр захирамжаар байгуулсан. Захирамжийн дагуу ажлыг 2021 оны 05 дугаар сард зохион байгуулна.

## **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн Барилгачдын холбоотой хамтран салбарын аж ахуйн нэгжүүдийн уулзалтыг зохион байгуулж, уулзалтад барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэл, зураг төсөл боловсруулах, авто замын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 36 аж ахуйн нэгжийн 42 удирдах болон инженер техникийн ажилтан хамрагдлаа.

Уулзалтаар 2020 оны ажлын гүйцэтгэлийн талаар танилцуулан 2021 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын талаар мэдээлэл, мөн барилгын материалын лабораторийн үйл ажиллагаа, ач холбогдол, шинээр нэвтэрч буй хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл, цахим системд шилжиж буй барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг хэрхэн авах талаар мэдээлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Аймгийн Засаг даргын захирамжаар Цагаан-овоо сумын Элст багийн нутаг дэвсгэрт Алтан Цагаан-овоо төслийн хүрээнд “Усны эрчим” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Степ голд” ХХК-ийн Нуруулдан уусгах талбайн байгууламжийн ажлыг хүлээн авах комисст ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр барилга угсралтын ажлыг хүлээн авсан.

Гурванзагал, Чулуунхороот сумын нутаг дэвсгэрт “Элтрүүд” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Хүүхдэд ээлтэй орчин” төслийн хүрээнд хөдөөгийн цэцэрлэг сургуулийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох” ажлын “Гурванзагал сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр”, “Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр” ажилд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2021 оны А/08 дугаар тушаалын дагуу комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан.

Гурванзагал сумын нутаг дэвсгэрт “ЦОДММ” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй “Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Гурванзагал сум/ ажлын барилга угсралтын ажлын явцад техникийн хяналт хийсэн. Барилгын үндсэн хийц болон дүүргэлтийн ажил, дотор өрөг угсралтын ажил бүрэн дууссан ба халаалт, дотор шаврын ажил бүрэн хийгдэж, барилга угсралтын ажил 70 хувьтай хийгдэж байна. Дотор заслын ажил болон спорт заалны хана, таазны заслын ажлын материал бүрэн татагдсан ба барилга угсралтын ажлыг 2021 оны 7 дугаар сард бүрэн дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Сумдын хэмжээнд ашиглагдаж байгаа эрчим хүчний шугам сүлжээ, дэд станцуудын хамгаалалтын зурвасыг “Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлийн

33.2-т заасны дагуу 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийг баримтлан баталгаажуулан ирүүлэх чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлээд байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд Дорнод аймагт хэрэгжих “Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дорнод, Хэрлэн сум/”, “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилга, 200 ор /Дорнод, Хэрлэн сум/” төсөл, арга хэмжээний зураг төслийн ажлын эскиз болон ажлын зураг төсөл батлагдан Барилгын хөгжлийн төвд магадлалаар хянагдаж байна.

Барилга хот байгуулалтын Сайдын 55 дугаар тушаалын дагуу холбогдох мэдээ, тайланг хавсралт маягтын дагуу, мөн ашиглалтад орсон барилга байгууламжийн тайланг БМ-19 маягтын дагуу тус тус 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн гаргаж, Барилга хөгжлийн төвд хүргүүлсэн.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн Дорнод аймгийн 2018-2020 онд ашиглалтад орсон орон сууцны судалгааг бүрдүүлж загвар маягтын дагуу холбогдох газарт хүргүүлсэн. Мөн Дорнод аймгийн төв буюу Чойбалсан хотод орон сууц, бусад зориулалтай барилгад нийгмийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг соёл, боловсрол, тусгай зориулалтын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт, эрүүл мэнд, нийгмийн халамжийн хүүхэд хамгаалах, ахмадын төв зэрэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагын мэдээ судалгааг хавсралт маягтын дагуу гаргаж цахимаар хүргүүлсэн.

Барилга, Хот байгуулалтын сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын дагуу хот байгуулалтын мэдээллийн санг бүрдүүлж, боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглуулахтай холбогдсон аймгийн хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг хангах нэг эх үүсвэртэй иж бүрэн нэгдмэл мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглаж хэвших, хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангах ажлын хүрээнд Хэрлэн сумын 6, 7, 9 дүгээр багийн нийт 181 барилгын фасад зургийг авч, судалгаа мэдээллийг цаасан хэлбэрээр бүрдүүлээд байна.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

- Хэрлэн голын сав газрын захиргаа, Буйр нуур Мэнэнгийн талын сав газрын захиргаатай хамтран 2021 онд байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг угтан зохион байгуулах төлөвлөгөөг боловсрууллаа. Уг төлөвлөгөөний дагуу байгаль орчны сэдэвт 25 контентийг



Жаран телевизтэй хамтран бүтээхээр төлөвлөөд байна. 3 дугаар сард Дэлхийн Ойн өдөр, Дэлхийн усны өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдэд зориулан Хэрлэн голоо хамгаалцгаая, Усны тухай хууль тогтоомж, ус ашиглах зөвшөөрөл гэрээтэй холбоотой асуудал, Ус ба амьдрал, Усны экосистем, Усыг аривлан хэмнэх, Ой ба амьдрал сэдвүүдээр тус бүр 5 минутын цахим контентийг Жаран телевизээр хийлгэж цахим хуудсууд болон орон нутгийн телевизүүдээр цацуулаад байна.

- 3-р сарын 21-ний өдөр тохиодог Олон улсын ойн өдрийн хүрээнд Сургуулийн өмнөх боловсрол болон ЕБС-ын бага ангийн хүүхдүүдэд зориулсан 5 минутын танин мэдэхүйн контент бэлтгэн аймгийн Боловсролын газартай хамтран аймгийн бүх сургууль, цэцэрлэгүүдийн анги танхимаар гаргаж, мөн цахим орчин, орон нутгийн Жапан телевизээр нэвтрүүлэн ойн өдрийг олон нийтэд таниулан ой модны хэрэглээ, ач холбогдол, өнөөгийн нөхцөл байдал, хамгаалах, нөхөн сэргээх арга замыг ухуулан сурталчиллаа.
- Усны үнэлэмж, үнэ цэнэ сэдэвт 2021 оны дэлхийн усны өрийг тохиолдуулан Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг усны салбарын байгууллагуудын дунд "3.22" цэнгээнт нэвтрүүлэгийг Хэрлэн голын сав газрын захиргаа зохион байгууллаа. Уг нэвтрүүлэгт

➤ Чойбалсан хотын усан хангамжийн ус түгээх байр, усан сангуудын хашаанд хэмжилт хийж, тооцоолон 2021 онд БОХНСЗ-аар 12 усан сан, ус түгээх байрыг сонгон хашаанд агаарын бохирдол, хөрсний эвдрэлээс хамгаалах зорилгоор зүлэг, мод тарих ажлын даалгаварыг боловсруулан тендер зарлаад байна.

➤ Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-уудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага сургууль”-д тус газрын Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээллэх албаныхан хамрагдлаа.

➤ “Бүх нийтээр мод тарих” аяны 2021 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан Удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан дээр урьдчилсан байдлаар танилцуулан санал, зөвлөмж авлаа.

Дорнод аймгийн Дашбалбар, Цагаан-Овоо, Матад, Халхгол, Чулуунхороот, Баян-Уул сумдад хэрэгжиж байгаа Монгол орны Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэх биологийн олон янз байдал орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжих KFW төслөөс зохион байгуулж байгуулсан тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад өөрийн орон нутгийн байгалийн болон соёлын өв, нөөцийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, тэдгээрийг таньж судлах, мэдлэг чадвар олгож, чадавхжуулах зорилго бүхий цахим уулзалтад оролцлоо. Энэ оны 5 дугаар сард төсөлд хамрагдсан сумдын Ерөнхий боловсролын сургуулийн биологийн танхимын тоног төхөөрөмж, сургалтын материалыг иж бүрнээр хангаж, эко кабинет тохижуулж өгөх юм.

## **СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

➤ Аймгийн Засаг даргын тамгын газар, Мерит төсөлтэй хамтран Аймгийн хүний нөөцийн ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтаар меррит төслийн зөвлөх Вилл Гау болон Меррит төслийн хүний нөөцийн мэргэжилтнүүд мэдээлэл хийлээ.

➤ Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах нь сэдвээр аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Соёлмаатай хамтран албан хаагчдад мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа.

➤ Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Ойн нөхөн сэргээх асуудал” үндэсний 5 дугаар чуулганд Ойн албаны дарга С.Мөнхсайхан, ойжуулалт, цөлжилт, ТББ, нөхөрлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Уянгоо нар цахимаар оролцлоо.

- Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтанд амжилттай суралцсан Байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт- шинжилгээ үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Нансалмаа, Ойжуулалт, цөлжилт, ТББ, нөхөрлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Уянгоо нарт Үнэмлэхийг гардууллаа.

### СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХҮРЭЭНД:

“Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”, “Хэмжил зүйн тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хэлтсийн дэргэдэх Орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөлийн 3 дугаар хурлаар дараах газруудад тохирлын гэрчилгээ олгосон.

Үйлчилгээ		
д/д	Нэр төрөл	3 дугаар хурал
1.	Хүнсний дэлгүүр	4
2.	Хүнсний мухлаг	1
3.	Супермаркет	1
4.	Цайны газар	1
<b>7.</b>	<b>Нийт</b>	<b>7</b>

Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн баталгаажуулалт		
Д/д	Бүтээгдэхүүний нэр төрөл	Тохирлын гэрчилгээний тоо
1.	Талх, талхан бүтээгдэхүүн	2
2.	Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн	1
3.	<b>Нийт</b>	<b>3</b>

- Экспортын бүтээгдэхүүн баталгаажуулалт

Д/д	Нэр төрөл	Тохирлын гэрчилгээний тоо	Хэмжээ /тн/	Аж ахуйн нэгж
1.	Хар тугалганы баяжмал	48	3072	“Шинь шинь” ХХК
2.	Цайрын баяжмал	49	3136	
3.	Хайлуур жонш	4	2000	
	<b>Нийт</b>	<b>101</b>	<b>8039</b>	

- Стандартын лавлагаа, мэдээлэл

д/д	Стандартын төрөл	Стандарт	Иргэн	ААН
1.	MNS	37	3	2
2.	ISO	-	-	-
3.	<b>Нийт</b>	<b>37</b>	<b>3</b>	<b>2</b>

- Цахилгаан хэмжих хэрэгслийн чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	1 фаз	3 фаз
1.	Цахилгааны тоолуур	2	2
2.	<b>Нийт</b>	<b>4</b>	

- Эзлэхүүн зарцуулалтын чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Тоо /ш/
1.	Усны тоолуур	285
2.	Автоцистрн	60
3.	<b>Нийт</b>	<b>345</b>

- Механик, даралт, температурын чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Тоо /ш/
1.	Бүх төрлийн жин	43
2.	Даралт температур	12
3.	Авто пүү	4
4.	<b>Нийт</b>	<b>59</b>

